



НИЙСЛЭЛИЙН  
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

Ахмадуудыг хүлээн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 6.16.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын ахмад настны эрхийг хамгаалах өдөр, Монголын ахмадын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд манай байгууллагад ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хүлээн авч хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Байгууллагын ахмадуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 465,000 (дөрвөн зуун жаран таван мянган) төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас гаргахыг Нягтлан бодогч (С.Ганчимэг)-д зөвшөөрсүгэй.

3. Ахмадуудыг хүлээн авах бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллахыг Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Б.Оюунтуяад үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНБОЛД



Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын 2024 оны ...<sup>09</sup> дүгээр сарын <sup>05</sup> ны өдрийн ...<sup>1/30</sup> дүгээр тушаалын хавсралт



Ахмадуудаа хүлээн авах төсөв

| №  | Зардлын нэр                  | Дүн         |
|----|------------------------------|-------------|
| 1. | Ахмадууд /4 хүн x 100.000/   | 400.000 төг |
| 2. | Цай, кофе, ус ундааны зардал | 65.000 төг  |
|    | Дүн                          | 465.000 төг |